



## “МОНГОЛ ТАМГА” ТӨААТҮГ-ЫН 2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

**Аудитын код: САГ-2018/77/СТА-ТӨҮГ**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг  
Утас: 261663  
Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)

Аудитын менежер С.Оюунгэрэл  
Утас: 99032466  
Цахим хаяг: [oyungerels@audit.gov.mn](mailto:oyungerels@audit.gov.mn)

Аудитор Ш.Ичинхорлоо  
Утас: 99044192  
Цахим хаяг: [ichinkhorloosh@audit.gov.mn](mailto:ichinkhorloosh@audit.gov.mn)

Ай Жэй Эй Эйч аудит ХХК-ийн захирал Г.Энхмаа  
Утас: 99040059 450279  
Цахим хаяг: [Enkhmaa\\_56@yahoo.com](mailto:Enkhmaa_56@yahoo.com)

Чанарын хяналтын мэргэжилтэн Л.Оюунцэцэг  
Утас: 99073014  
Цахим хаяг: [oyuntsetsegl@yahoo.com](mailto:oyuntsetsegl@yahoo.com)

Аудитор Г.Бэлэгт  
Утас: 99088333  
Цахим хаяг: [g\\_belegt@yahoo.com](mailto:g_belegt@yahoo.com)

Улаанбаатар хот  
2018 он



## Агуулга

---

1. Аудитын гэрчилгээ .....	0
2. Аудитын тайлан .....	1
2.1 Оршил .....	1
2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	1
2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	2
2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үдүн 2	
2.5 Дотоод хяналт .....	3
2.6 Шилэн дансны мэдээлэл .....	4
2.7 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар .....	4
2.8 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл.....	4
2.8.1 Орлогын талаар .....	4
2.8.2 Ажлаас буруу халсны хохирлын талаар.....	4
2.8.3 Авлага, өр төлбөрийн талаар.....	4
2.8.4 Зардлын талаар.....	4
2.9 Анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	5
2.10 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд .....	5
2.11 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл .....	5
2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	5
2.13 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар: .....	6
2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	6
3. Менежментийн захидал.....	7
3.1 Орлогын талаар.....	8
3.2 Ажлаас буруу халсны хохирлын талаар .....	9
3.3 Авлага, өр төлбөрийн талаар .....	10
3.4 Зардлын талаар .....	11
4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	12
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	13
4.2 Аудит хийгдсэн орлогын тайлан.....	15
4.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	17

## 1. Аудитын гэрчилгээ

---

“МОНГОЛ ТАМГА” ТӨҮГ-ЫН  
ДАРГА Д.РЭНЦЭНТАВХАЙ ТАНАА

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Монгол тамга” ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол “Монгол тамга” ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл


Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Монгол тамга” ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

### Аудитын гол асуудал

- Тайлант оны борлуулалтын орлогыг НӨАТ-ын тайланд 106.8 сая төгрөгөөр дутуу тайлагнасан.
- Ажилтанг үндэслэлгүй ажлаас халсны улмаас Шүүхийн шийдвэрээр 2.4 сая төгрөг, шүүхийн шийдвэр гарснаас хойш ажилд авах хөдтөлүү 8 сарын цалинд 2.4 сая төгрөгийг даргын тушаалаар, бүгд 4.7 сая төгрөгийн хохирол учруулсан



- Монгол тамга ТӨААТҮГ-ын удирдлага нь урьд онуудад үүсгэсэн өр төлбөрөө төлөөгүй мөртлөө нэмж 8.1 сая төгрөгийн өр төлбөр үүсгэж нийтдээ байгууллагадаа 130.6 сая төгрөгийн өртэй байна.
- Санхүүгийн тайланд тусгагдсан 55.7 сая төгрөгийн авлага, 97.0 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байна.
- Удирдлагын хэрэгцээний 4.4 сая төгрөгийн шатахуун, 0.4 сая төгрөгийн сэлбэгийг данс бүртгэлд тусгалгүй шууд зардлаар тайлагнасан бөгөөд анхан шатны баримтгүй байна. Мөн 20.8 сая төгрөгийн ажил гүйлгээг анхан шатны баримтгүйгээр зардлаар хүлээн зөвшөөрч тайлагнасан.
- Байгууллагаас Улуснэт, Юнивишн, Ёкозунанэт гэсэн 3 байгууллагад интернетийн төлбөрт 0.7 сая төгрөг төлсөн, гэрээ авчирч үзүүлээгүй, хувь хүний шагналын мялаалганд 0.5 сая төгрөг, хувь хүний хувийн газрын кадастрын зургийн төлбөрт 0.2 сая төгрөг, мөн тушаалаар дарга нябо нарын хүүхдийн сургалтын төлбөрт 3.1 сая төгрөг төлсөн.
- Түүхий эдийн үнэнд зориулж Хятадын иргэн Сэтгэлтэд 15.1 сая төгрөгийг үндэслэх анхан шатны баримт, гэрээ хэлцэлгүйгээр олгосон, Сэтгэлтийн замын зардалд 1.1 сая төгрөг, хүлээн авалтын зардалд 0.5 сая төгрөгийг төсөв удирдамжгүй, анхан шатны баримтгүй зарцуулсан /голцуу архи авсан/, зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг”, “Үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### **Үүрэг, хариуцлага**

“Монгол тамга” ТӨҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

/Ц.НАРАНЧИМЭГ/

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ХЯЗГААРЛАЛТАЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

## 2. АУДИТЫН ТАЙЛАН

### 2.1 Оршил

“Монгол тамга” ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайланг Монгол тамга” ТӨААТҮГ-ын захирал Д.Рэнцэнтавхай танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг ба материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд борлуулалтын орлогыг НӨАТ-ын тайланд дутуу тайлагнасан, НӨАТ-ын буцаалтын тооцоо хийгээгүй, ажилтанг ажлаас буруу халсны хохирлыг гэм буруутай албан тушаалтнаар төлүүлэх, тайланд тусгагдсан өр авлагыг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй, худалдан авсан шатахуун, сэлбэг хэрэгслийг данс бүртгэлд тусгалгүй шууд зардлаар тайлагнасан, анхан шатны баримтын бүрдэлгүй гүйлгээг зардлаар хүлээн зөвшөөрсөн зэрэг зөрчилд өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

### 2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага


Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Монгол тамга” ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Монгол тамга” ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

“Монгол тамга” ТӨААТҮГ нь 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, нягтлан бодох бүртгэлийн бодлого, прорам хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.



“Монгол тамга” ТӨААҮГ -ын аудитыг 2018 оны 02 дугаар сарын 23-наас 2018 оны 03 дугаар сарын 13–ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 03 дугаар сарын 15-нд эцэслэн баталгаажуулж, “Монгол тамга” ТӨААҮГ-ын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, “Ай Жэй Эй Эйч Аудит” ХХК-ийн аудитор Г.Бэлэгт, аудиторын туслах Я.Чинцэцэг нар хариуцаж хэрэгжүүлэв.

“Монгол тамга” ТӨААҮГ нь 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2018 оны 03 сарын 04-нд Ай Жэй Эй Эйч Аудит ХХК-д ирүүлсэн байна.

### **2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

“Монгол тамга” ТӨҮГ нь Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, ААНОАТ-ын тухай хууль, НӨАТ-ын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, ХХОАТ-ын тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон эдгээр хуулиудтай нийцүүлэн гаргасан Засгийн газрын тогтоол, Сангийн сайдын тушаал, СТОУС зэрэг эрх зүйн актуудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж иржээ.

Засгийн газрын 2018 оны 1-р сарын 10-ны өдрийн 9 дүгээр тогтоолоор “Монгол тамга” ТӨААҮГ-ыг татан буулгах шийдвэр гарсан байна.

### **“Монгол тамга” ТӨҮГ-ын зорилго нь**

“Монгол тамга” ТӨААҮГ -ын үйл ажиллагааны үндсэн зорилт нь Монгол улсын хууль тогтоомж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын баталсан зорилтот түвшингийн үзүүлэлтийг бүрэн хангаж ажиллахад оршино гэж байгууллагын чиг үүргийг тодорхойлсон байна. Үйл ажиллагааны чиглэл нь ХЗДХЯ-ны тусгай зөвшөөрлөөр тамга, тэмдэг үйлдвэрлэх, түүнд нийцүүлэн хууль тогтоомжоор хориглоогүй бизнесийн үйл ажиллагаа эрхлэх явдал юм.

### **Үйл ажиллагааны стратегийн зорилт**


Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд “Монгол тамга” ТӨААҮГ нь санхүүгийн тогтвортой байдлыг хангаж, техник технологийг сайжруулах, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх, өртөг зардлыг хямдруулах, өр авлагыг бууруулан, бүтээгдэхүүний чанарыг сайжруулж, үр ашигтай удирдлагаар хангаж ажиллах үүрэгтэй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн газрын захирал удирдана” гэж заасны дагуу “Монгол тамга” ТӨҮГ-ын захирал нь удирдаж эд хөрөнгийг захиран зарцуулж байна.

### **2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000–1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар “Монгол тамга” ТӨААҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлангийн дансдын уламжлалт болон хяналтын өрсөдлийг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/



Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар нарийвчилсан 11 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

“Монгол тамга” ТӨААҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

“Монгол тамга” ТӨААҮГ нь санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг “Лидер” програмаар гүйцэтгэн санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайлангаа гаргасан байна.

## 2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Ингэж хянахдаа “Монгол тамга” ТӨААҮГ-ын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтыг санхүүгийн, хяналтын эрсдэл байвал зохих горимтой харьцуулан шалгаж үзсэн. Үүний үр дүнд удирдлагаас зайлшгүй хэрэгжүүлэх дотоод хяналт сул байна

## 2.6 Орлого, зардал, гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2016 оны 12 сарын 20-ны өдрийн 282 дугаар тогтоолоор “Монгол тамга” ТӨААҮГ-ын 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг баталсан байна.

"МОНГОЛ ТАМГА" ТӨҮГ-ЫН 2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АУДИТ ХИЙГДСЭН ЗОРИЛТОТ ТҮВШИНГИЙН БИЕЛЭЛТ						
Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Өмнөх оны гүйцэтгэл	2017 он		Өөрчлөлт	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү (3-2)	Хувь (3*100/2)
А	Б	1	2	3	4	5
<b>Нийт орлого:</b>	<b>мян/төг</b>	<b>197,655.3</b>	<b>185,000.0</b>	<b>172,063.5</b>	<b>(12,936.5)</b>	<b>93.0</b>
Цэвэр борлуулалт	мян/төг	197,487.8	185,000.0	170,396.0	(14,604.0)	92.1
Үйл ажиллагааны бус орлого	мян/төг	167.5		1,667.5	1,667.5	
<b>Нийт зардал:</b>	<b>мян/төг</b>	<b>206,812.0</b>	<b>181,050.0</b>	<b>178,507.5</b>	<b>(2,542.5)</b>	<b>98.6</b>
Үйл ажиллагааны зардал	мян/төг	206,812.0	181,050.0	178,507.5	(2,542.5)	98.6
Үйл ажиллагааны бус зардал	мян/төг				-	
Үүнээс: Удирдлагын зардал	мян/төг	158,972.1			-	
Татварын өмнөх ашиг / алдагдал /	мян/төг	(9,156.7)	3,950.0	(6,190.8)	(10,140.8)	(156.7)
<b>Цэвэр ашиг / алдагдал /</b>	<b>мян/төг</b>	<b>(9,156.7)</b>	<b>3,555.0</b>	<b>(6,444.0)</b>	<b>(9,999.0)</b>	<b>(181.3)</b>
Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	Төгрөг	1.05	0.98	1.04	0.06	106.0
Нийт авлага	мян/төг	180,019.30	64,452.0	188,434.7	123,982.7	292.4
Нийт өр төлбөр	мян/төг	83,749.60	58,000.0	96,975.5	38,975.5	167.2
Хөрөнгө оруулалт, их засвар	мян/төг				-	
Ажиллагсдын тоо	хүн /тоо	8.00	8.0	7.0	(1.0)	87.5
Цалингийн сан	сая.төг		95,000.0	83,746.1	(11,253.9)	88.2

Тайлант жилд зорилтот түвшингийн орлогын төлөвлөгөө 93%-аар биеллж 7%-аар тасалдуулсан байна. Зарлагын төлөвлөгөө 98,6%-ийн гүйцэтгэлтэй гарч 254.3 сая

төгрөгөөр хэмнэсэн байгаа боловч орлогын төлөвлөгөө тасалдсаны улмаас **6.4 сая төгрөгийн алдагдалтай** ажилласан байна. Авлага өмнөх оноос 8.4 сая төгрөгөөр, өр төлбөр 13.2 сая төгрөгөөр өсчээ.

## 2.7 Шилэн дансны мэдээлэл

Засгийн газрын 2014 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 394 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай” журмыг дагаж мөрдөөгүй байгаа бөгөөд 2017 оны эхний хагас жилийн зорилтот түвшингийн биелэлт, мөн хагас жилийн санхүүгийн тайлангаас өөр мэдээлэл оруулаагүй байна.

## 2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу 6 дансанд нийт 11 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв. Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

## 2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

### 2.9.1 Орлогын талаар

Тайлант оны борлуулалтын орлогыг НӨАТ-ын тайланд 106.8 сая төгрөгөөр дутуу тайлагнасан. НӨАТ-ын тайланг хугацаанд нь гаргаагүй, НӨАТ-ын буцаалтын тооцоо хийгээгүй.

Шийдвэрлэсэн нь: НӨАТ-ын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Албан татварыг доор дурдсан журмаар ноогдуулна”, 8.1.1-д “Бараа ажил үйлчилгэээ импортлосон буюу экспортолосон, түүнчлэн борлуулсан бол тухай бүрт” гэсэн заалтыг мөрдөж ажиллах зөвлөмж өгөв.

### 2.9.2 Ажлаас буруу халсны хохирлын талаар


Нярав Дэлгэрнасанг үндэслэлгүй ажлаас халсны улмаас Шүүхийн шийдвэрээр 2.4 сая төгрөг, шүүхийн шийдвэр гарснаас хойш ажилд авах хүртэлх 3 сарын цалинд 2.4 сая төгрөгийг захирлын тушаалаар, нийт 4.8 сая төгрөгийг нярав асан Дэлгэрнасангийн хохиролд олгосон.

Шийдвэрлэсэн нь: Захиргааны ерөнхий хуулийн 103.1-д “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ” гэснийг, 103.2-т “Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна” гэснийг мөрдөж төрийн өмчит байгууллагыг хохиролгүй болгох зөвлөмж өгөв.

### 2.9.3 Авлага, өр төлбөрийн талаар

Санхүүгийн тайланд тусгагдсан 55.7 сая төгрөгийн авлага, өр төлбөрийг өгөлгийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: НББ-ийн тухай хуулийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч худалдан





авагчтай тооцоо хийж үлдээдлийг баталгаажуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтыг хэрэгжүүлж үүргээ биелүүлж ажиллах зөвлөмж өгөх

#### 2.9.4 Зардлын талаар

Удирдлагын хэрэгцээний 4.4 сая төгрөгийн шатахуун, 0.4 сая төгрөгийн сэлбэгийг данс бүртгэлд тусгалгүй шууд зардлаар тайлагнасан бөгөөд анхан шатны баримтгүй байна. Мөн 20.8 сая төгрөгийн ажил гүйлгээг анхан шатны баримтгүйгээр зардлаар хүлээн зөвшөөрч тайлагнасан.

Шийдвэрлэсэн нь: НББОУС-2 "Бараа материал"-д “Бараа материалыг өртөө болон цэвэр боломжит үнийн аль багаар нь үнэлнэ” гэсэн заалтыг, НББ-ийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудыг мөрдөж ажиллах зөвлөмж өгөв.

#### 2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 9 дүгээр тогтоолоор “Монгол тамга” ТӨААТҮГ-ыг татан буулгах шийдвэр гарсан.

“Монгол тамга” ТӨААТҮГ-ын удирдлага нь аудитын явцад шаардлагатай:

- А. Бараа материалын тайлан
- Б. Тооллогын бүртгэл
- В. Албан байгууллагуудтай хийсэн гэрээнүүд /интернетийн/
- Г. Хамтын гэрээ гэх мэт материалуудыг ирүүлсэнгүй.

Мөн өмнөх аудитаар хүргүүлсэн төлбөрийн актыг биелүүлсэн боловч зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, өмнөх зөрчил дахин давтаж төрийн өмчит байгууллагын хөрөнгийг удирдлага дур мэдэн зарцуулж байгаа нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т "Албан тушаалтан албаны бүрэн эрхээ хувийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн зорилгод ашиглахгүй бөгөөд албан үүрэгт нь нөлөөлөхүйц аливаа харилцаанаас ангид байна", 6.4-т "Албан тушаалтан иргэний болон хуулийн этгээдийн зүгээс тавьсан албан үүрэгтэй нь зөрчилдөх хувийн ашиг сонирхлын асуудал болон зан байдлыг тэвчиж, албан үүргээ гүйцэтгэхдээ нийтийн ашиг сонирхлыг хувийн болон тусгай ашиг сонирхлоос илүүд үзнэ" гэсэн заалтуудыг зөрчиж байна.

#### 2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД


“Монгол тамга” ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал үгүй болно.

#### 2.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

“Монгол тамга” ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 441.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба 149.2 сая төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өгч 292.6 сая төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага өглөө.

#### 2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

“Монгол тамга” ТӨААТҮГ-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар 4 зөвлөмж өгөгдсөн байна. Өгөгдсөн 4 зөвлөмжийг 50 хувь биелүүлсэн байна.



#### **2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгов.

“Монгол тамга” ТӨААҮГ-ын 2017 оны санхүүгийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 178507,5 мянган төгрөг бөгөөд 2 хувиар материаллаг байдлыг тодорхойлж, хүлээн зөвшөөрөх алдааны түвшинг 3.6 сая төгрөгөөр баталгаажууллаа. Учир нь: Нийт орлого болон зардлаас материаллаг түвшинг тогтооход материаллаг түвшин өндөр гарч байгаа тул зөвхөн нийт зардлаас 2 хувиар материаллаг байдлын түвшинг тогтоох нь зохимжтой гэж үзлээ.

#### **2.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ**

“Монгол тамга” ТӨААҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дээрх алдаа зөрчлийг эс тооцвол “Монгол тамга” ТӨААҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна.

Аудитлагдсан тайланд санхүүгийн тайлан 5 хуудас, хавсралтууд 6 хуудсыг хавсаргав.

### 3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

---

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь “Монгол тамга” ТӨААҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



### 3.1 Орлогын талаар

### Тэргүүлэх ач холбогдол №1

#### ҮАГ-ын ажиглалт

Тайлант оны борлуулалтын орлогыг НӨАТ-ын тайланд 106.8 сая төгрөгөөр дутуу тайлагнасан. НӨАТ-ын тайланг хугацаанд нь гаргаагүй, НӨАТ-ын буцаалтын тооцоо хийгээгүй байна.

Энэ нь НӨАТ-ын тухай хуулийн 8.1-д “Албан татварыг доор дурдсан журмаар ногдуулна” 8.1.1-д “Бараа ажил үйлчилгээг импортолсон буюу экспортолсон, түүнчлэн борлуулсан бол тухай бүрт” гэж заасныг зөрчсөн байна.

#### ҮАГ-ын зөвлөмж

- Тайланг цаг хугацаанд нь гаргах
- НӨАТ-ын буцаалтын тооцоо хийх
- Тайлагналын алдааг залруулах

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 07 сарын 02-нд үндэсний аудитын газарт ирүүлэх

#### Эрсдэлүүд

Үнэн зөв байдал, иж бүрэн байх, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдийг зөрчсөн байх. Байгууллагын санхүүгийн тайланд тусгагдсан ажил гүйлгээ үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх батламж мэдэгдэл зөрчигдөх эрсдэлтэй.

#### Төсвийн захирагчийн хариу

Санхүүгийн тайланд НӨАТ бүрэн тусгагдаад явж байгаа. Харин татвартай тооцоо нийлж хаалтын баланс гаргана.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ХЯЗГААРЛАЛТАЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

**3.2 АЖЛААС БУРУУ ХАЛСНЫ ХОХИРЛЫН  
ТАЛААР**

**Тэргүүлэх ач холбогдол №2**

**ҮАГ-ын ажиглалт**

Нярав Дэлгэрнасанг үндэслэлгүй ажлаас халсны улмаас Шүүхийн шийдвэрээр 2.4 сая төгрөг, шүүхийн шийдвэр гарснаас хойш ажилд авах хүртлэх 3 сарын цалинд 2.4 сая төгрөгийг даргын тушаалаар, бүгд 4.8 сая төгрөгийг нярав асан Дэлгэрнасангийн хохиролд олгосон.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д *"Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ"*, 103.2-т *"Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна"* гэж заасныг зөрчсөн байна.

**Эрсдэлүүд**

Холбогдох хууль тогтоомж болон эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг зөрчсөн.

**ҮАГ-ын зөвлөмж**

Холбогдох хуулийн дагуу шийдвэрлэж төрийн өмчит байгууллагыг хохиролгүй болгох.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 1-ний дотор ҮАГ-т ирүүлэх

**Төсвийн захирагчийн хариу**

Шүүхийн шийдвэрийн дагуу О.Дэлгэрнасанг ажилд нь эгүүлэн авахаар тушаал шийдвэр гаргасан боловч тэтгэмжээ аваад өөрийн хүсэлтээр халагдах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
**ХЯЗГААРЛАЛТАЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

**3.3 Авлага, өр төлбөрийн талаар**

**Тэргүүлэх ач холбогдол №3**

**ҮАГ-ын ажиглалт**

Санхүүгийн тайланд тусгагдсан 55.7 сая төгрөгийн авлага, 97.0 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч худалдан авагчтай тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг зөрчсөн байна.

**ҮАГ-ын зөвлөмж**

НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч худалдан авагчтай тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтыг хэрэгжүүлж үүргээ биелүүлж ажиллах

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 1-ний дотор ҮАГ-т ирүүлэх

**Эрсдэлүүд**

Холбогдох хууль тогтоомж болон эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг зөрчсөн.

**Төсвийн захирагчийн хариу**

Олон жил он дамжсан өр, авлага байгаа. ХХААЯ-аас авах 16.4 сая төгрөг Авто худалдааны цогцолбороос авах 33.0 сая төгрөг, Анод банкинд өгөх 11.6 сая төгрөг, Аврагас зоос ХЗХ-д өгөх 0.02 сая ам долларын асуудлыг тухайн харилцагчидыг татан буулгах комисст албан ёсоор хандан шийдвэрлүүлэхээр болсон.

**3.4 Зардлын талаар**

**Тэргүүлэх ач холбогдол №4**

**ҮАГ-ын ажиглалт**

Удирдлагын хэрэгцээний 4.3 сая төгрөгийн шатахуун, 0.4 сая төгрөгийн сэлбэгийг данс бүртгэлд тусгалгүй шууд зардлаар тайлагнасан бөгөөд анхан шатны баримтгүй байна. Мөн 20.8 сая төгрөгийн ажил гүйлгээг анхан шатны баримтгүйгээр зардлаар хүлээн зөвшөөрч тайлагнасан.

Энэ нь НББОУС-2 "Бараа материал"-д заасны. *"Бараа материалыг өртөг болон цэвэр боломжит үнийн аль багаар нь үнэлнэ"* гэсэн заалтыг, НББ-ийн тухай хуулийн 13.1-д *"Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно"*, 13.7-д *"Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"* гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

**Эрсдэлүүд**

Холбогдох хууль тогтоомж стандартыг зөрчих

**ҮАГ-ын зөвлөмж**

Холбогдох стандарт, хууль журмыг мөрдөж ажиллах

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 07 сарын 1-нд ҮАГ-т ирүүлнэ.

**Төсвийн захирагчийн хариу**

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн санхүүгийн ажилтанд танилцуулсан.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
**ХЯЗГААРЛАЛТАЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

**3.5 УДИРДЛАГАТАЙ ХОЛБООТОЙ ӨР ТӨЛБӨРИЙН ТАЛААР**

**Тэргүүлэх ач холбогдол №1**

**ҮАГ-ын ажиглалт**

Тайлант онд удирдлага нь зээл урьдчилгаа нэрээр 11.5 сая төгрөгийн авлага үүсгэж 3.5 сая төгрөгийг төлж 8.1 сая төгрөгийн авлага үүсгэжээ. Урьд оны авлагын үлдэгдэл 122.5 сая байсан бөгөөд тайлант оны эцэст **130.6** сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байна. Мөн байгууллагаасаа Улуснэт, юнивишн, Ёкозунанэт гэсэн 3 байгууллагад интернетийн төлбөрт 0.7 сая төгрөг төлсөн бөгөөд гэрээгүй, бэлтгэл хурандаа Цэрэнчимэдийн шагналын мялаалганд 0.5 сая төгрөг, Дэлгэрсайхан, Жаргалсайхан нарын хувийн газрын кадастрын зургийн төлбөрт 0.2 сая төгрөг, мөн тушаалаар Рэнцэнтавхайн хүүхдийн сургалтын төлбөрт 1.2 сая төгрөг, нягтлан бодогч Өнөбатын хүүхдийн сургалтын төлбөрт 1.9 сая төгрөг, нийт **4.5** сая төгрөгийг зарцуулсан зэрэг зөрчил илэрлээ.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т *"Албан тушаалтан албаны бүрэн эрхээ хувийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн зорилгод ашиглахгүй бөгөөд албан үүрэгт нь нөлөөлөхүйц аливаа харилцаанаас ангид байна"* 6.4-д *"Албан тушаалтан иргэний болон хуулийн этгээдийн зүгээс тавьсан албан үүрэгтэй нь зөрчилдөх хувийн ашиг сонирхлын асуудал болон зан байдлыг тэвчиж, албан үүргээ гүйцэтгэхдээ нийтийн ашиг сонирхлыг хувийн болон тусгай ашиг сонирхлоос илүүд үзнэ"* гэж заасныг зөрчсөн байна.

**Эрсдэлүүд**

Холбогдох хууль тогтоомж стандартыг зөрчих


**ҮАГ-ын зөвлөмж**

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн зохих заалтуудыг зөрчсөн тул хариуцлага тооцох, хуулийн байгууллагад шилжүүлэхээр Төсвийн ерөнхийлөн захирагчид албан шаардлага хүргүүлэх

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 07 сарын 1-нд ҮАГ-т ирүүлнэ.

**Төсвийн захирагчийн хариу**

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн санхүүгийн аудитын байгууллага танилцуулсан.






#### 4 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН

##### 4.1 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

		(төгрөгөөр)	
Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2016.оны 12-р сарын.31	2017оны.12-р сарын.31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	26,318,895.90	37,805,973.62
1.1.2	Дансны авлага	177,892,821.20	185,968,171.20
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	1,056,468.90	1,396,511.35
1.1.4	Бусад авлага	1,070,000.00	1,070,000.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	55,236,485.48	55,569,262.80
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10			
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>261,574,671.48</b>	<b>281,809,918.97</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	42,338,554.82	29,039,098.20
1.2.2	Биет бус хөрөнгө	295,166.67	141,166.67
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>42,633,721.49</b>	<b>29,180,264.87</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>304,208,392.97</b>	<b>310,990,183.84</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	2,189,500.00	2,189,500.00
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	35,838,101.93	49,063,909.44
2.1.1.4	НДШ-ийн өглөг		
2.1.1.5	Богино хугацаат зээл	36,999,734.00	36,999,734.00
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	8,722,310.50	8,722,310.50
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах		



	бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12			
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>83,749,646.43</b>	<b>96,975,453.94</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5			
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>83,749,646.43</b>	<b>96,975,453.94</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч : - төрийн	46,645,097.40	46,645,097.40
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	12,366,998.00	12,366,998.00
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	161,446,651.14	155,002,634.50
2.3.10	Тайлант үеийн ашиг	(9,546,743.77)	(6,444,016.64)
	Өмнөх үеийн ашиг	170,993,394.91	161,446,651.14
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>220,458,746.54</b>	<b>214,014,729.90</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>304,208,392.97</b>	<b>310,990,183.84</b>

#### 4.2 Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан  
(төгрөгөөр)

	ҮЗҮҮЛЭЛТ	2016.оны 12-р сарын.31	2017 оны.12-р сарын.31
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>197,487,829.09</b>	<b>170,395,972.73</b>
2	Борлуулалтын өртөг	33,712,724.30	18,237,463.18
3	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>163,775,104.79</b>	<b>152,158,509.55</b>
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого	167,453.47	899,503.93
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого		768,000.00
	Орлогын дүн		
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	158,972,062.47	150,394,133.07
11	Санхүүгийн зардал	2,897,200.00	130,400.00
12	Бусад зардал	11,230,000.00	9,199,879.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		(292,380.50)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>(9,156,704.21)</b>	<b>(6,190,779.09)</b>
19	Орлогын татварын зардал		253,237.55
20	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(9,156,704.21)</b>	<b>(6,444,016.64)</b>
21	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>		
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>(9,156,704.21)</b>	<b>(6,444,016.64)</b>
23	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>	<b>-</b>	<b>-</b>
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	<b>Орлогын нийт дүн</b>	<b>(9,156,704.21)</b>	<b>(6,444,016.64)</b>
25	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>		



### 4.3 Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	<b>2015 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>46,645,097.40</b>	<b>12,366,998.00</b>	<b>170,993,394.91</b>	<b>230,005,490.31</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				-
3	<b>Залруулсан үлдэгдэл</b>				-
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(9,546,743.77)	(9,546,743.77)
5	Бусад дэлгэрэнгүй орлого				-
6	Өмчид гарсан өөрчлөлт				-
7	Зарласан ногдол ашиг				-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		-		-
9	<b>2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>46,645,097.40</b>	<b>12,366,998.00</b>	<b>161,446,651.14</b>	<b>220,458,746.54</b>
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			-	-
11	<b>Залруулсан үлдэгдэл</b>				-
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(6,444,016.64)	(6,444,016.64)
13	Бусад дэлгэрэнгүй орлого				-
14	Өмчид гарсан өөрчлөлт				-
15	Зарласан ногдол ашиг				-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				-
17	<b>2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>46,645,097.40</b>	<b>12,366,998.00</b>	<b>155,002,634.50</b>	<b>214,014,739.90</b>


ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**01** ХЯЗГААРЛАЛТАЙ  
САНАЛ ДҮГИЙН

#### 4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан  
(төгрөгөөр)

	ҮЗҮҮЛЭЛТ	2016.оны 12-р сарын.31	2017оны.12-р сарын.31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	<b>218,861,316.00</b>	<b>187,732,640.00</b>
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	218,347,062.00	187,732,340.00
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	514,254.00	
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтийн орлого		
	Бусад мөнгөн орлого		300.00
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	<b>192,433,446.26</b>	<b>160,781,138.21</b>
	Ажиллагчдад төлсөн	75,238,688.00	64,922,171.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	20,653,614.11	17,423,720.95
	Бараа материал худалдан авахад төлсөн	35,739,197.00	19,039,691.00
	Ашиглалтын зардалд төлсөн	15,412,600.00	15,737,600.00
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	6,057,900.00	5,406,660.00
	Хүүний төлбөрт төлсөн		
	Татварын байгууллагад төлсөн	14,946,983.80	12,236,959.76
	Даатгалын төлбөрт төлсөн		
	Бусад мөнгөн зарлага	24,384,463.35	26,014,335.50
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>26,427,869.74</b>	<b>26,951,501.79</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	<b>227,453.47</b>	<b>5,399,403.93</b>
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	60,000.00	
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		4,500,200.00
	Хүлээн авсан хүүний орлого	167,453.47	899,203.93
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	<b>10,975,428.50</b>	<b>16,080,206.00</b>
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,885,000.00	1,255,200.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд		



	төлсөн		
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	9,090,428.00	14,825,000.00
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(10,747,974.53)</b>	<b>(10,680,796.07)</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		-
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Төрөл бүрийн хандив		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		<b>4,783,628.00</b>
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		4,783,628.00
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг		
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-</b>	<b>(4,783,628.00)</b>
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>15,679,895.21</b>	<b>11,487,077.72</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	10,639,000.69	26,318,895.90
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	26,318,895.90	37,805,973.62